



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 635

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаад харилцааны яам болон түүний харьяа Дипломат төлөөлөгчийн газруудын албан хэрэгцээнд зориулан 2019 оны үйл ажиллагааны давсан орлогоос нийт 1,836,203,051.79 (нэг тэрбум найман зуун гучин зургаан сая хоёр зуун гурван мянга тавин нэгэн төгрөг далан есөн мөнгө) төгрөгт багтаан хөрөнгө олж авахыг зөвшөөрч, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001099

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 12 дугаар сарын 24-ний
өдрийн 635 дугаар тогтоолын хавсралт

**Гадаад харилцааны яам болон түүний харьяа Дипломат
төлөөлөгчийн газруудад худалдаж авах хөрөнгийн үнийн дээд
хязгаар**

Д/д	Хөрөнгийн нэр	ДТГ	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Тээврийн хэрэгсэл	12	1,475,945,419.45
2	Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	7	360,257,632.34
			1,836,203,051.79
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,836,203,051.79 (нэг тэрбум найман зуун гучин зургаан сая хоёр зуун гурван мянга тавин нэгэн төгрөг далан есөн мөнгө)